



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чулуут сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2023/14-НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2023 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор П.Цэцэгдулам Цахим хаяг: Tsetsegdulamp@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	Error! Bookmark not defined.
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	Error! Bookmark not defined.
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	Error! Bookmark not defined.
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	Error! Bookmark not defined.
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	Error! Bookmark not defined.
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	Error! Bookmark not defined.
3.5.1 Орон нутгийн төсвийн орлого, зардлын төлөвлөлт	Error! Bookmark not defined.
3.5.2 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5 Төсвийн шууд захирагчийн аудитын дүнгийн талаар	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	11
5.1 Төлбөрийн акт	11
5.2 Албан шаардлага	11
5.2 Зөвлөмж	
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	12

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хариуцлагатай хувьцаат компани
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс:976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2023.03.24 № 141
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Чулуут сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чулуут сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэгдсэнтэй холбоотой Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, газрын төлбөр, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдуулсан хувь хүний орлогын албан татварын орлогыг сумын төсөвт төвлөрүүлдэг болсон байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын засаг дарга нь 2022 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 128 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 74.0 хувьтай үнэлсэн байна.

D:\2019\АЛБАН БИЧИГ\2021 он\2022 А4 тоот.doc

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,031,756.8	592,870.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	115,419.8	176,065.7
33	АВЛАГА	457,610.2	320,241.2
35	БАРАА МАТЕРИАЛ	427,325.8	65,162.4
36	НӨӨЦИЙН БАРАА	31,401.0	31,401.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,437,996.1	2,220,099.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,437,996.1	2,220,099.4
39200	Биет хөрөнгө	4,316,806.4	2,136,887.4
39300	Биет бус хөрөнгө	121,189.7	83,212.0
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,469,752.9	2,812,969.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	11,639.2	9,721.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,639.2	9,721.5
41300	Өглөг	11,639.2	9,721.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,458,113.7	2,803,248.1
51	Засгийн газрын хувь оролцоо	5,458,113.7	2,803,248.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,772,010.4	616,818.4
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,772,010.4	616,818.4
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,261,748.8	1,261,748.8
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	19,240.9	19,240.9
51200	Хуримтлагдсан үр дүн	1,291,449.6	827,843.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,113,664.0	77,597.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,469,752.9	2,812,969.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,597,300.1	1,400,968.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	183,039.5	356,157.0
110	Орлогын албан татвар	60,619.4	218,360.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	60,619.4	218,341.2
11001	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	00.00	18.9
113	Хөрөнгийн албан татвар	92,782.7	107,038.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	29,637.4	30,758.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	628,353.7	349,516.1
120	Нийтлэг татварын бус орлого	628,353.7	349,516.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,785,906.9	695,295.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,033,776.9	957,623.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,033,776.9	957,623.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,264,612.8	923,498.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,027,442.3	394,441.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	245,899.9	47,921.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	134,591.6	192,781.5
2104	Хангамж, бараа материалын зардал	142,010.0	36,924.8
2105	Нормативт зардал	347,285.5	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,813.3	42,396.9
2107	Томилолт, зочны зардал	5,110.5	1,144.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,528.2	28,319.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	305,931.6	179,568.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	769,164.1	34,124.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	563,523.1	443,345.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	121,995.9	2,989,621.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	441,527.2	-2,546,275.6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,094,530.7	1,262,162.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	183,039.5	356,157.0
110	Орлогын албан татвар	60,619.4	218,360.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	60,619.4	218,341.2
	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	18.9
113	Хөрөнгийн албан татвар	92,782.7	107,038.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	29,637.4	30,758.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	7,924.8	8,506.2
1181	Газрын төлбөр	131.1	670.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	21,581.5	21,581.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	210,127.0	210,709.9
120	Нийтлэг татварын бус орлого	210,127.0	210,709.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,701,364.2	695,295.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,718,367.2	795,397.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,718,367.2	795,397.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,949,904.6	761,272.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,043,634.6	392,440.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	248,978.6	54,633.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	134,424.1	193,887.5
2104	Хангамж, бараа материалын зардал	120,329.6	33,961.5
2105	Нормативт зардал	198,195.2	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	66,057.8	30,848.5
2107	Томилолт, зочны зардал	5,110.5	1,144.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,240.4	28,549.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,933.8	25,807.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	768,462.6	34,124.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	376,163.5	466,765.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	168,469.0	298,119.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	168,469.0	298,119.6
2200	Дотоод эх үүсвэрээр	168,469.0	298,119.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-168,469.0	-298,119.6
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-163,000.0	-108,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	163,000.0	108,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	44,694.4	60,645.9
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	70,725.4	115,419.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	115,419.8	176,065.7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,016,586.4	5,016,586.4
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,016,586.4	5,016,586.4
2	Тайлант үеийн үр дүн	441,527.2	441,527.2
3	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,458,113.7	5,458,113.7
3	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,458,113.7	5,458,113.7
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-108,591.0	-108,591.0
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,349,522.7	5,349,522.7
5	Тайлант үеийн үр дүн	-2,546,275.6	-2,546,275.6
5	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,803,248.1	2,803,248.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

№	Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,357,683.1	1,130,699.4	226,983.7	83.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	747,193.7	724,579.8	22,613.9	97.0
210	БАРАА , АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	713,971.4	691,357.5	22,613.9	96.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	385,675.0	370,165.7	15,509.3	96.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд төлөх шимтгэл	47,710.0	45,004.1	2,705.9	94.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	183,958.4	177,505.2	6,453.2	96.5
2104	Хангамж бараа материалын зардал	31,772.5	31,750.5	22.0	99.9
2106	Эд хогшил урсгал засварын зардал	13,832.4	13,832.4	-	100.0
2107	томилолт зочны зардал	1,004.0	1,004.0	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,211.5	26,288.0	(2,076.5)	108.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,807.6	25,807.6	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,222.3	33,222.3	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,222.3	33,222.3	-	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	399,888.4	298,119.6	101,768.8	74.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	210,601.0	108,000.0	102,601.0	51.3
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,357,683.1	1,139,373.0	218,310.1	83.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,028,112.9	984,912.5	43,200.4	95.8
35	ТӨСӨВ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	329,570.2	154,460.5	175,109.7	46.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	115,340.4	(115,340.4)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	124,014.1	(124,014.1)	
6	ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ	2.0	2.0	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	65.0	65.0	-	100.0
63	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	65.0	65.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,217.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,217.34
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,314.77
2104	Хангамж бараа материалын зардал	300.00
2106	Эд хогшил урмгал засварын зардал	16,711.12
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	1,303.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	902.58
2133	Олгосон санхүүжилт шилжүүлэг	902.58
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	19,217.34
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,217.34

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитаар залруулагдаагүй нийт 70,477.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч зөрчил арилгуулах 4 албан шаардлага хүргүүлээ.

3.1 Албан шаардлага

3.1.1 Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг тулган шалгахад 10 зээлдэгчтэй холбоотой 30,382.6 мянган төгрөгийн 1-7 жилийн насжилттай хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна.” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.1.2 Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг тулган шалгахад хадгаламжийн хүүгийн орлого 17,407.3 мянга, улсын тэмдэгтийн хураамж 1,114.7 мянга, түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласны төлбөр 7,183.6 мянга, хог хаягдлын хураамж 1,245.5 мянга, малын тоо толгойн албан татвар 13,143.4 мянга нийт 5 нэр төрлийн 40,094.5 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчиж байна

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.1.3 Төсөвт байгууллагын өөрийн орлогыг гүйцэтгэлээр 10226.5 мянган төгрөг төвлөрүүлснийг батлагдсан төлөвлөгөөний хэмжээнд төвлөрүүлж зарцуулсан гэж орлогыг 2076.5 мянган төгрөгөөр бууруулан гүйлгээ хийж батлагдсан төсвийг хэтрүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7 “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах, 20.2.9. “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах” гэж заасныг зөрчиж хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын санхүү албаны даргад Төрийн аудитын тухай хуулийн 42.1-д заасны дагуу хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Чулуут сумын ТТЗ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Чулуут сумын ТТЗ	4	70,477.1	0	0	2	70,477.1	0	0	2	2	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Чулуут сумын ТТЗ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0